### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Заг сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

БСШУСпортын сайдын 2017.02.07-ны өдрийн А/40 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Боловсролын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Заг сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Заг сумын ЕБС-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1146752.2 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 32176.9 мянган төгрөгөөр буюу 9.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 80,029.7 | 80,029.7 |
| Авлага | 61.8 | - | (61.8) |
| Бараа материал | 67,975.2 | 64,610.1 | (3,365.1) |
| Үндсэн хөрөнгө | 1,046,538.3 | 1,002,112.4 | (44,425.9) |
| **Нийт хөрөнгө** | **1,114,575.3** | **1,146,752.2** | 32,176.9 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,114,575.3 | 1,146,752.2 | 32,176.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,114,575.3** | **1,146,752.2** | 32176.9 |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө буюу Улсын төсвийн төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл 80,029.7 мянган төгрөг байна. Орон нутгийн төсөв буюу байгууллагын тогтмол зардлын дансны үлдэгдэл 18,495.9 мянган төгрөгийг буцааж төвлөрүүлсэн.

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эхэнд 61.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст үлдэгдэлгүй, дансны авлагыг тайлант онд бүрэн барагдуулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 64,610,1 мянган төгрөг болж өмнөх оноос 3,365.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлан онд төсвийн хөрөнгөөр 77,894.3 мянга, Баянхонгор аймгийн БШУГ-аас 3,032.6 мянга, НҮБ-ын хүүхдийн сангаас 1,193.0 мянга, нийт

4,225.6 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, тайланд онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд 79,515.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 5,969.2 мянган төгрөгийн хөрөнгийг сургуулийн захирлын 2022.12.28-ны өдрийн А/52 дугаар тушаалаар акталж, байгууллагын данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,002,112.4 мянган төгрөг болж 44,425.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 11,955.0 мянга, БШУЯамны хөрөнгө оруулалтаар ирсэн 15,916.6 мянган төгрөгийн багш нарын зөөврийн компьютерыг үнэ төлбөргүй үндсэн хөрөнгөнд орлого авч, Аймгийн ИТХ-ын 2022.09.16-ны өдрийн 10/46 дугаар тогтоолоор 13,235.2 мянган төгрөгийн хөрөнгө акталж, байгууллагын данснаас хассантай холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,146,752.2 мянган төгрөг болж 32,176.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн харилцах дансны үлдэгдэл өссөн, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлүүд буурсантай холбоотой байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 620,967.3 мянга, нийт зарлагыг 620,967.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 57,105.3 мянган төгрөгөөр буурч 563,862.0 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 627,809.6 мянган төгрөг болгож 63,947.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 80112, 80226, 80312, 81605, 81801, 81806, 81816, 81823, 81834, 81835, 81848 арга хэмжээг санхүүжүүлэхээр 742,138.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас ОН-ийн төсвөөс 114,328.9 мянган төгрөгийг, улсын төсвөөс 627,809.6 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр ОН-ийн төсвөөс 114,328.9 мянган төгрөгийн, улсын төсвөөс 627,809.6 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож, зарцуулагдаагүй ОН-ийн төсвийн үлдэгдэл 18,495.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, улсын төсвийн үлдэгдэл 80,029.7 мянган төгрөгийг тайлант оны санхүүгийн тайланд үлдэгдэлтэй гаргасан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 651,088.9 мянган төгрөг буюу 87.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 98,525.6 мянган төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| 1 | 71802-Ерөнхий боловсрол | 1910.4 | 1910.4 | 0 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | 80226-Байр ашиглалтын үйлчилгээ | 955.2 | 955.2 | 0 | 100 |
| 4 | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 2,196.9 | 2,196.9 | 0 | 100 |
| 5 | 81801-Үдийн цай хөтөлбөр | 38,470.9 | 35,632.5 | 2,838.4 | 92.6 |
| 6 | 81806-Дотуур байрны үйлчилгээ | 51,403.5 | 41,606.0 | 9,797.5 | 80.9 |
| 7 | 81816-хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 11,990.0 | 11,990.0 | 0 | 100 |
| 8 | 81823-Боловсролын байгууллагын багш хөгжил | 4,298.3 | 4,298.3 | 0 | 100 |
| 9 | 81834-Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа | 470,601.5 | 414,030.0 | 56,571.5 | 88 |
| 10 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 45,982.9 | 35,160.6 | 10,822.3 | 76.5 |
| 11 | 81848-Сурах бичгийн түрээс | 935.2 | 935.2 | 0 | 100 |
| 12 | 80112- Нийтлэг үйлчилгээ | 121,703.8 | 95,833.0 | 25,870.8 | 78.7 |
| | Нийт дүн | 750,448.6 | 644,548.0 | 105,900.6 | 85.9 |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

| № | Хөтөлбөр | Зарцуулах төсөв | Зарцуулсан | Хэрэгжилтийн явц | Эдийн засгийн ангилал | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | | |
| 2 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | - | | |
| 2 | **АРГА ХЭМЖЭЭ 80226** | - | - | - | | |
| 3 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,910,400 | 1,910,400 | 100.00 | 2 | Байгууллагын байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилтийг цэвэрлэгээ, халдваргүйтгэл, эрүүл аюулгүй ажлын байрын орчин нөхцөлийн бүрдүүлэхэд зарцуулж ажиллалаа. |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,910,400 | 1,910,400 | 100.00 | 21 | |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 1,910,400 | 1,910,400 | 100.00 | 210 | |
| 4 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,910,400 | 1,910,400 | 100.00 | 2101 | |
| 5 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,910,400 | 1,910,400 | 100.00 | 210901 | |
| 5 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | | | |
| 6 | **АРГА ХЭМЖЭЭ 80312** | - | - | | | |
| 6 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 955,200 | 955,200 | 100.00 | 2 | Багш нар ажлын байранд хамтран суралцах, сургалт семинарын зардлыг шийдвэрлэснээр багшийн хөгжилд ахиц гарсан сайн үр дүнтэй байна. |
| 7 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 955,200 | 955,200 | 100.00 | 21 | |
| 7 | Бараа, үйлчилгээний зардал | 955,200 | 955,200 | 100.00 | 210 | |
| 8 | Бараа үйлчилгээний бусад зардал | 955,200 | 955,200 | 100.00 | 2101 | |
| 8 | Бараа үйлчилгээний бусад зардал | 955,200 | 955,200 | 100.00 | 210901 | |
| 9 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | | | |
| 9 | **АРГА ХЭМЖЭЭ 81605** | - | - | | | |
| 10 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,196,900 | 2,196,900 | 100.00 | 2 | Багш ажилтны эрүүл мэндийн үзлэгийн зардал шинээр батлагдаж, журмын дагуу ажлын хэсэг үйл ажиллагаар хэрэгжүүлж ажиллав. Багш ажилтны сэтгэл ханамж өндөр байна. |
| 10 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 2,196,900 | 2,196,900 | 100.00 | 21 | |
| 11 | Бараа, үйлчилгээний зардал | 2,196,900 | 2,196,900 | 100.00 | 210 | |
| 11 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,196,900 | 2,196,900 | 100.00 | 2101 | |
| 12 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,196,900 | 2,196,900 | 100.00 | 210901 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | | | |
| 13 | **АРГА ХЭМЖЭЭ 81801** | - | - | | | |
| 13 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 38,470,900 | 35,632,500 | 92.62 | 2 | Үдийн хоол хөтөлбөрт 1-5 дугаар ангийн сурагчид хамрагдан, БЕГ-ын загвар менюны дагуу сэт хоолны үйлчилгээнд хамрагдав. Хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгдсэн үр дүнтэй байлаа. |
| 14 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 38,470,900 | 35,632,500 | 92.62 | 21 | |
| 14 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 38,470,900 | 35,632,500 | 92.62 | 213 | |
| 15 | Бусад урсгал шилжүүлэг | 38,470,900 | 35,632,500 | 92.62 | 2132 | |
| 15 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 38,470,900 | 35,632,500 | 92.62 | 213205 | |
| 16 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | | | |
| 16 | **АРГА ХЭМЖЭЭ 81806** | - | - | | | |
| 17 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 66,914,300 | 60,899,078 | 91.01 | 2 | Сургуулийн дотуур байранд 45 хүүхэд амьдарч, дотуур байрын үйлчилгээ авч байна. Дотуур байранд багш 1, жижүүр 3, тогооч 2 ажиллаж, дотуур байрын сурагчдад үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Нормативын дагуу хоол хүнсээр хэвийн тасралтгүй ханган ажилласан. |
| 17 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 66,914,300 | 60,899,078 | 91.01 | 21 | |
| 18 | Бараа, үйлчилгээний зардал | 66,914,300 | 60,899,078 | 91.01 | 210 | |
| 18 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 13,302,400 | 8,336,595 | 62.67 | 2101 | |
| 19 | Үндсэн цалин | 13,302,400 | 8,336,595 | 62.67 | 210101 | |
| 19 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,662,700 | 911,313 | 54.81 | 2102 | |
| 20 | Тэтгэврийн даатгал | 1,130,700 | 698,894 | 61.81 | 210201 | |
| 20 | Тэтгэмжийн даатгал | 133,000 | 53,105 | 39.93 | 210202 | |
| 21 | ҮОМШӨ ний даатгал | 106,400 | 42,484 | 39.93 | 210203 | |
| 21 | Ажилгүйдлийн даатгал | 26,600 | 10,621 | 39.93 | 210204 | |
| 22 | Эрүүл мэндийн даатгал | 266,000 | 106,210 | 39.93 | 210205 | |
| 22 | Нормативт зардал | 34,653,400 | 30,573,050 | 88.23 | 2105 | |
| 23 | Хоол, хүнс | 34,653,400 | 30,573,050 | 88.23 | 210502 | |
| 23 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,785,000 | 1,785,000 | 100.00 | 2101 | |
| 24 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,785,000 | 1,785,000 | 100.00 | 210901 | |
| 24 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | | | |
| 25 | **АРГА ХЭМЖЭЭ 81816** | - | - | | | |
| 25 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 11,990,000 | 11,990,000 | 100.00 | 2 | Цахим шилжилттэй холбоотойгоор төрөөс сургалтын тоног төхөөрөмжөөр нөхөн хангах зардал шийдэгдсэнээр манай сургууль 1 суурин компьютер, 7 таблет бүхий цахим сургалтын танхимыг шинээр байгуулж ажиллалаа. |
| 26 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 11,990,000 | 11,990,000 | 100.00 | 21 | |
| 26 | Бараа, үйлчилгээний зардал | 11,990,000 | 11,990,000 | 100.00 | 210 | |
| 27 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,990,000 | 11,990,000 | 100.00 | 2109 | |
| 27 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,990,000 | 11,990,000 | 100.00 | 210901 | |
| 28 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | | | |
| 28 | **АРГА ХЭМЖЭЭ 81823** | - | - | | | |
| 29 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,298,300 | 4,298,300 | 100.00 | 2 | Багшийн сургалтын үйл ажиллагааны зардал шийдвэрлэгдсэнээр мэргэжлийн ЗАН, багш нарын хамтын ажиллагаа сайжирч, багш бүрийн хөгжилд чанарын ахиц гарч байна. |
| 29 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 4,298,300 | 4,298,300 | 100.00 | 21 | |
| 30 | Бараа, үйлчилгээний зардал | 4,298,300 | 4,298,300 | 100.00 | 210 | |
| 30 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,298,300 | 4,298,300 | 100.00 | 2109 | |
| 31 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,298,300 | 4,298,300 | 100.00 | 210901 | |
| 31 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | | | |
| 32 | **АРГА ХЭМЖЭЭ 81834** | - | - | | | |
| 32 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 470,601,500 | 414,029,975 | 87.98 | 2 | 2022 онд багш тус бүрд цахим хэрэглээний зардал, хичээл үйлдвэрлэлийн зардлыг тооцон олгодог болсон ба эдгээр зардлын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийн алхам бүрд багшийн оролцоог хангаж ажилласнаар багшийн санхүүгийн үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлж, сургалтын хэрэглэгдэхүүнээ багш өөрөө төлөвлөн худалдан авах боломжийг бүрдүүлж өгсөн сайн талтай ажил болсон. Эдгээр зардлууд нь цахим шилжилтийн цаг үед багшид тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж чадсан тул багш нар сэтгэл ханамж өндөр байсан. |
| 33 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 470,601,500 | 414,029,975 | 87.98 | 21 | |
| 33 | Бараа, үйлчилгээний зардал | 470,601,500 | 414,029,975 | 87.98 | 210 | |
| 34 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 405,576,800 | 354,539,237 | 87.42 | 2101 | |
| 34 | Үндсэн цалин | 300,784,700 | 267,884,170 | 89.06 | 210101 | |
| 35 | Нэмэгдэл | 102,681,300 | 84,550,551 | 82.34 | 210102 | |
| 35 | Урамшуулал | 2,110,800 | 2,104,516 | 99.70 | 210104 | |
| 36 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50,697,100 | 45,163,138 | 89.08 | 2102 | |
| 36 | Тэтгэврийн даатгал | 34,474,000 | 33,297,060 | 96.59 | 210201 | |
| 37 | Тэтгэмжийн даатгал | 4,055,800 | 2,966,518 | 73.14 | 210202 | |
| 37 | ҮОМШӨ ний даатгал | 3,244,600 | 2,373,214 | 73.14 | 210203 | |
| 38 | Ажилгүйдлийн даатгал | 811,200 | 593,304 | 73.14 | 210204 | |
| 38 | Эрүүл мэндийн даатгал | 8,111,500 | 5,933,043 | 73.14 | 210205 | |
| 39 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 4,775,900 | 4,775,900 | 100.00 | 2108 | |
| 39 | Мэдээллийн технологийн зардал | 4,775,900 | 4,775,900 | 100.00 | 210806 | |
| 40 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,551,700 | 9,551,700 | 100.00 | 2201 | |
| 40 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,387,900 | 2,387,900 | 100.00 | 210901 | |
| 41 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,163,800 | 7,163,800 | 100.00 | 210902 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 41 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | | | |
| 42 | **АРГА ХЭМЖЭЭ 81835** | - | - | | | |
| 42 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 45,982,900 | 35,160,627 | 76.46 | 2 | 2022 онд сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд олгогдсон төсвийн хүрээнд тухайн ангилалд хамаарах ажилтны цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг шийдвэрлэж олгосон ба улсын хэмжээнд зохион байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд манай байгууллага 4-р түвшинд эрэмбэлэгдэж, олгогдсон урамшууллыг тооцож олгосон байна. Гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоо нь багш ажилтны ажилдаа хандах хариуцлагыг нэмэгдүүлж, сургалтын үйл ажиллагааны чанарыг ахиулахад түлхэц болж байгаа сайн талтай байна. |
| 43 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 45,982,900 | 35,160,627 | 76.46 | 21 | |
| 43 | Бараа, үйлчилгээний зардал | 45,982,900 | 35,160,627 | 76.46 | 210 | |
| 44 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 40,873,700 | 31,706,011 | 77.57 | 2101 | |
| 44 | Үндсэн цалин | 34,280,800 | 23,950,538 | 69.87 | 210101 | |
| 45 | Нэмэгдэл | 2,742,500 | 4,097,685 | 149.41 | 210102 | |
| 45 | Урамшуулал | 3,850,400 | 3,657,788 | 95.00 | 210104 | |
| 46 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,109,200 | 3,454,616 | 67.62 | 2102 | |
| 46 | Тэтгэврийн даатгал | 3,474,300 | 2,423,674 | 69.76 | 210201 | |
| 47 | Тэтгэмжийн даатгал | 408,700 | 257,735 | 63.06 | 210202 | |
| 47 | ҮОМШӨ ний даатгал | 327,000 | 206,188 | 63.05 | 210203 | |
| 48 | Ажилгүйдлийн даатгал | 81,700 | 51,547 | 63.09 | 210204 | |
| 48 | Эрүүл мэндийн даатгал | 817,500 | 515,471 | 63.05 | 210205 | |
| 49 | **ХӨТӨЛБӨР 71802** | - | - | | | |
| 49 | **АРГА ХЭМЖЭЭ 81848** | - | - | | | |
| 50 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 935,200 | 935,200 | 100.00 | 2 | Сурах бичгийг түрээсээр эзэмшүүлэх журмын дагуу шаардлагатай сурагчдад түрээсийн сурах бичгээр үйлчлэн, орлогыг төвлөрүүлэн ажилласнаар сургуулийн хэмжээнд сурах бичгийн хангамж 98%-тай ажиллаж байна. |
| 50 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 935,200 | 935,200 | 100.00 | 21 | |
| 51 | Бараа, үйлчилгээний зардал | 935,200 | 935,200 | 100.00 | 210 | |
| 51 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 935,200 | 935,200 | 100.00 | 2108 | |
| 52 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 935,200 | 935,200 | 100.00 | 210801 | |
| 52 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 750,448,600 | 724,577,761 | 96.55 | | |
| 53 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 627,809,600 | 627,809,600 | 100.00 | 1310 | |
| 53 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 627,809,600 | 627,809,600 | 100.00 | 131007 | |
| 54 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 935,200 | 935,200 | 100.00 | 120004 | |
| 54 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 935,200 | 935,200 | 100.00 | 1200041 | |
| 55 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | - | 1200042 | |
| 55 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | 4 | |
| 56 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 80,029,740 | - | 5 | |
| 56 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | 6 | |
| 57 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | 61 | |
| 57 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 35 | 32 | 93.80 | 62 | |
| 58 | Удирдах ажилтан | 2 | 2 | 100.00 | 620001 | |
| 58 | Гүйцэтгэх ажилтан | 23 | 21 | 93.75 | 620002 | |
| 59 | Үйлчлэх ажилтан | 10 | 9 | 93.75 | 620003 | |
| 59 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | 249 | 249 | 100.00 | 63 | |
| 60 | Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид | 249 | 249 | 100.00 | 630 | |
| 60 | Төрийн өмчит ЕБС | 249 | 249 | 100.00 | 630001 | |
| 61 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 35 | 32 | 93.80 | 65 | |
| 62 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/ | 25 | 23 | 100.00 | 650004 | |
| 62 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/ | 10 | 9 | 93.80 | 650009 | |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-

ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэзням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ө.Март, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч У.Сүхбаатар нар зурж байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 176,817.7 мянган төгрөгөөс 1,768.2 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 1,237.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд нийт 750,448.6 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас иж бүрэн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 8 | 1 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | 0 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 148 | 1 | 2 |

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 743,073.7 мянган төгрөгийн 12 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 80,779.5 мянган төгрөгийн 20 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой төгрөгийн 80 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 40,249.4 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн даргын 2022.05.31-ны өдрийн 30 дугаар албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 5. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | 74,234.5 | 2 | 74,234.5 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **74,234.5** | **2** | **74,234.5** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгөв.

### 5.1. Зөвлөмж

2. Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, халаалт, дулаанаар хангах гэрээг байршуулаагүй бөгөөд гэрэл цахилгаанд 5.471.5 мянга, халаалтын зардалд 79,046.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг цаг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| **Дүн** | **1** | | **0** | **0** | **0** | **0** | **1** | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нийт дүн** | **1** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **1** | **0** |

-oOo-